

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга,
тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.20 № 87.
танай _____ ны № _____ т

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ
ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ОЮУНЗАЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 98.6 хувиар өссөн байна. Мөн тайлант онд 3 албан хаагчийн сул орон тоотой холбоотойгоор 77.9 сая төгрөгийн цалингийн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус байгууллага нь эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх арга хэмжээнд 3.9 сая, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 140.3 сая төгрөг,

632502100

урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 37.6 сая, гэр бүлийн хөгжил хамгааллын арга хэмжээнд 14.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.2 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	4,091.1	16,331.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	449,230.9	506,559.0
Нийт хөрөнгийн дүн	453,322.0	522,890.5
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	453,322.0	522,890.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,105,422.2	2,647,582.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	815,141.5	1,223,884.8
Үйл ажиллагааны зардлын дүн	751,053.8	1,177,972.0
Үйл ажиллагааны үр дүн	64,087.7	45,912.8
Үйл ажиллагааны бус үр дүн	962.0	(936.6)
Үйл ажиллагааны нийт үр дүн	812,393.1	541,677.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,041,334.5	2,105,422.2
Тайлант оны үр дүн	64,087.7	45,639.9
Эцсийн үлдэгдэл	2,105,422.2	208,955.3
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	761,930.3	1,181,507.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	706,080.3	1,138,923.9
Үйл ажиллагааны ЦМГ	55,850.0	42,584.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(55,850.0)	(42,584.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	(0.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,017,481.6
Урсгал зардал	-	1,017,481.6
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,017,481.6
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус газар нь аймгийн Хүүхэд гэр бүл хөгжил гэсэн нийгмийн суурь болсон зорилтод бүлэгт хүрч ажилладаг орон нутгийн засаг захиргааны байгууллага бөгөөд шууд харьяаллын 4 хууль 40 гаруй зорилтыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй ажилладаг.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нийгэм, хууль эрх зүйн салбарын байгууллагуудтай уялдан ажиллаж аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо зэрэг салбар дундын нэгжийн ажлын албаар ажилладаг байна.

Нийгмийн байгууламжийн анхан шатны нэгж болох гэр бүлд төрийн байгууллагын үйлчилгээг хүргэх, Хүүхэд гэр бүлийн эрхийг хамгаалах тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх тогтолцоог нэмэгдүүлэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөлд буй хүүхдэд хамгааллын үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тухайн байгууллага нь тайланд онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 6 зориулалт арга хэмжээний батлагдсан төсвийг зориулалт арга хэмжээний дагуу зарцуулахдаа хэрэгжүүлэх арга хэмжээний дээд байгууллагаас батлагдсан норм баримтлан ажиллаагүй хөтөлбөр, зориулалт арга хэмжээний зардлыг хооронд нь шилжүүлэн зарцуулсан байна.

Тав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,808.9 төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 10,908.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,900.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Ажилчдад илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг олгохдоо илүү тооцоолон олгосон нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.2, 20.2.4-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргэгдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардлаас “Булган лиг” насанд хүргэгчдийн шагналд 1,900.0 мянган төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулахыг таслан зогсоож Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын тоо	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	2	12,808.9	1.00	10,908.9	-	-	1	1,900.0				
Дүн	2	12,808.9	1.00	10,908.9	-	-	1	1,900.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	1	21,220.0			1	21,220.0		
Нийт дүн	1	21,220.00	-	-	1	21,220.00	0	0